


ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2023/02/06-2023/02/10

ТОП 20 индекс



ХАМГИЙН ИХ ДҮНГЭЭР АРИЛЖИГДСАН

Талх Чихэр	1,792,987,600
Монголын хөрөнгийн бирж	360,113,670
Инвескор ББСБ	305,518,274
Эрдэнэ ресурс девелопмент	224,291,348
АПУ	210,087,889

ХАМГИЙН ИХ ӨСӨЛТТЭЙ

	Үнийн дүн	Өсөлт
Түшиг Уул	57,300	23.08%
Монгол керамик	870,900	20.00%
Алтайн зам	1,179,600	14.97%
Хүрд	362,100	14.95%
Глобал Монголиа холдинг	91,200	14.93%

ХАМГИЙН ИХ БУУРАЛТАЙ

	Үнийн дүн	Бууралт
Хорин хоёрдугаар бааз	4,408,600	-33.33%
Сонсголон бармат	110,000	-25.77%
Силикат	30,090	-15.00%
Гутал	180,000	-12.93%
Голомт банк	116,077,970	-11.22%

МХБ-ын Top 20 индекс өнгөрсөн долоон хоногт 37,812.41 нэгжид хүрч 0.62 %-иар унасан үзүүлэлттэй байв. Хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 6.82 их наяд ₮ хүрээд байна.

Энэ оны эхний 7 хоногт Монголын хөрөнгийн биржээр 86 компанийн 4.9 тэрбум ₮-ийн 15.9 сая ширхэг үнэт цаас арилжаалагдсан байна.

Үүнээс 615.1 сая ₮-ийн ХБҮЦ, 308 сая ₮-ийн компанийн бонд, 308.4 сая ₮-ийн хамтын хөрөнгө оруулалтын сан, 3.69 тэрбум ₮-ийн хувьцааны арилжаа хийгдсэн байна.

Хамгийн их дүнгээр арилжаалагдсан эдгээр хувьцаанууд нь өнгөрсөн 7 хоногийн нийт хоёрдогч зах зээлийн хувьцааны арилжааны **78.4%**-ийг эзэлж байна. Хувьцаат компанийн 1-р ангилалд багтдаг Талх Чихэр ХК арилжааны үнийн дүнгээр тэргүүлж өнгөрсөн 7 хоногийн хувьцааны арилжааны 48.6%-ийг эзэлсэн байна. Мөн Монголын хөрөнгийн бирж, Инвескор ББСБ мөн тэргүүлсэн байна.

Өнгөрсөн долоон хоногт Хувьцаат компанийн 3-р ангилалд багтдаг барилгын материал үйлдвэрлэлийн Түшиг Уул ХК ханшийн өсөлтийн хувь хэмжээгээр тэргүүлсэн боловч арилжааны үнийн дүн харьцангуй бага байна.

Өнгөрсөн 7 хоногт 2021 оноос ашиг нь **4.5** дахин өссөн Голомт банк ХК-ийн хувьцааны ханш 116.1 сая ₮-ийн арилжаагаар **11.22%**-ийн уналт үзүүлсэн байна. Мөн Хорин хоёрдугаар бааз ХК 4.4 сая ₮-ийн арилжаагаар 33.33%-ийн уналт үзүүлсэн байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

+976 75100575

info@rhinosinvest.mn

www.rhinosinvest.mn

ДОТООД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2023/02/06-2023/02/10

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

ЛэндМН ББСБ болон Сэндли ББСБ ногдол ашиг олгохоор шийдвэрлэлээ.



ЛэндМН ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр хувьцаа эзэмшигчиддээ нэгж хувьцаанд **1.75₮** ногдох нийт цэвэр ашгийн 23.4% болох 1,293,778,000₮-ийг ногдол ашиг болгон 2023.04.30 дотор тараахаар шийдвэрлэсэн байна.

Тус компанийн зээлийн багц 2022 онд 2.1 дахин өсч 71.1 тэрбум төгрөгт хүрч, цэвэр ашиг 5.53 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.



Өнгөрсөн жил IPO хийсэн "Сэндли ББСБ" ХК 2022 онд 3.06 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж, тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс нийт хувьцаа эзэмшигчдээ нэгж хувьцаанд **2.75** төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэлээ.

"Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль"-ийн дагуу уул уурхайн бүтээгдэхүүнийг мхб-ээр дамжуулан арилжаалахаар засгийн газрын ээлжит хуралдаанаар шийдвэрлэлээ



2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас батлагдсан "Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль"-ийн дагуу 2023 оны 2 дугаар сарын 8-ны Засгийн Газрын ээлжит хуралдаанаар уул уурхайн бүтээгдэхүүнийг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-иар дамжуулан арилжаалахаар шийдвэрлэлээ.

Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам"-ын хүрээнд экспортод гаргах нүүрсний анхны арилжаа 2023/02/09-ны өдөр амжилттай явагдаж, "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн экспортод гаргах 5 багц буюу нийт 32,000 тонн хатуу коксжих нүүрсийг дуудлага арилжаагаар арилжлаа.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

